

Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл
/ III/04 – III/08 /

2019.03.07

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	Улаанбаатар хотод зохион байгуулагдсан орос хэлний хичээлийн Улсын төрөлжсөн олимпиадын 3-ын даваанд манай аймгийн багш, сурагчид амжилттай оролцож, багаараа 2 дугаар байр эзэллээ. Өлгий сумын ерөнхий боловсролын Билге-Тегин сургуулийн 12 дугаар ангийн сурагч Ж.Тансауле мөнгөн медаль хүртэж, ОХУ-д үнэ төлбөргүй суралцах эрхийг авсан бол ерөнхий боловсролын Зайд сургуулийн 9 дүгээр ангийн сурагч Н.Талант хүрэл медаль хүртсэн болно.		
2	Ерөнхий боловсролын 29 сургуулийн захирлууд Улаанбаатар хотод манлайлалын сургалтанд хамрагдаж, мэргэжлээ дээшлүүллээ.		
3	Сумдын соёлын төвийн ажилтнуудын “Наурыз әуен” теле нэвтрүүлгийг “Дербес” телевизтэй хамтран зохион байгуулсан. /Одоогоор 4 сум хамрагдсан, Наурызын баярыг хүртэл үргэлжлэх болно/		
4	Сумдын соёлын төвийн 2018, 2019 оны төлөвлөгөө, тайлан, хүний нөөцийн судалгааг авч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.		
5	Ерөнхий боловсролын сургуулийн бүх багш нараас Засаг даргын нэрэмжит шалгалт авагдсан.		
6	Бага ангийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Боловсролын хүрээлэнгийн багтай хамтран хэлэлцүүлэг зохион байгууллаа.		